

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн бус байгууллагын тухай хуульд  
нэмэлт оруулах тухай хуулийн төслийн  
талаар

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 22 дугаар зүйлд “Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй.” хэмээн иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх нь улс төрийн болон нийгэм соёлын бусад эрхээ эдлэх, хамтдаа улс орны хөгжлийн үйл явцад оролцох боломжийг хангахад чухал нөлөөтэй болохыг тодотгон гишүүн улс орнуудын Засгийн газрыг үүрэгжүүлсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө хэмээх Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10-т Монгол Улсын иргэн нь “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ... олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. ... олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” хэмээн иргэдийн эвлэлдэн нэгдэх, зохих хэлбэр бүхий байгууллагыг байгуулан нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлыг илэрхийлэх, хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэлийг заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилго 5-д “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, **төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин**, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэсэн зорилтыг дэвшүүлж, энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үе шатыг “Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо хангагдаж, хамтын ажиллагаа бэхжих нөхцөл бүрдэнэ.” гэж, “Иргэний нийгмийн байгууллагууд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3-т “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.” хэмээн тодорхойлж, улмаар тус чиглэлд аюулгүй байдлыг хангахын тулд “... аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллагаар... гүйцэтгүүлэх бодлого баримтална.”, “Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ” хэмээн тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт<sup>1</sup> нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилгыг дэвшүүлсэн болно.

### **Хуулийн төсөлд тусгасан үндэслэл, шаардлагын тухайд:**

Төрийн бус байгууллагын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших 24 жилийн хугацаанд нийгмийн өөрчлөлтийг дагаж төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, зохион байгуулалтын хэлбэрт ч томоохон өөрчлөлтүүд гарсан боловч иргэний нийгмийн бодлогын болон холбогдох зохицуулалтын өөрчлөлт дээрх хуульд ороогүй байна.

Мөн эдгээр төрийн бус байгууллага нь боловсрол, эрүүл мэнд, сургалт, халамжийн үйлчилгээ, эрүүл мэнд, төсөл хөтөлбөр гэх зэргээр нийт 19 чиглэлийн үйл ажиллагааг явуулахаар дээрх газарт бүртгүүлсэн байдаг бөгөөд нийгмийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн иргэний нийгмийн бусад бүрэлдэхүүн хэсэг болох улс төрийн нам, сүм, хийд, үйлдвэрчний эвлэл зэрэг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан Улс төрийн намын тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Улаан загалмай нийгэмлэгийн тухай хууль зэрэг иргэний нийгмийн гол хуулиудад иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагын чадамжийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох зорилго бүхий иргэний нийгмийн бодлоготой байх, уг бодлогыг батлах эрх бүхий байгууллагын талаар огт тусгаагүй байдаг.

Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд урт, дунд, богино хугацааны бодлоготой байхаар заасан бөгөөд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилго 5-д “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, **төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин**, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэсэн зорилтыг дэвшүүлж, энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үе шатыг “Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо хангагдаж, хамтын ажиллагаа бэхжих нөхцөл бүрдэнэ.” гэж, “Иргэний нийгмийн байгууллагууд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж заасан байдаг. Харин уг хуульд заасан богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын талаар, эсхүл уг бодлогын баримт бичиг нь дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгах эсэх талаар хууль эрх зүйн орчинд огт тусгагдаагүй байдаг.

Иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагын чадамжийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох зорилго бүхий иргэний нийгмийн талаар төрөөс баримтлах бие даасан бодлоготой зайлшгүй шаардлагатай байна.

---

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт.

Тодруулбал, сүм хийд, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, худалдаа аж үйлдвэрийн танхим, улаан загалмайн байгууллага зэрэг эрх зүйн тусгай зохицуулалт бүхий байгууллага нь иргэний нийгмийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эдгээрийг бүгдийг хамруулсан нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна.

Ийнхүү ардчиллын үнэт зүйлийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, төрийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналтад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих, чадварлаг, хараат бус иргэний нийгмийг бүрдүүлэх, төр, иргэний нийгмийн бүтээлч хамтын ажиллагааг төгөлдөршүүлэхэд чиглэсэн төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогыг тодорхойлж, ийнхүү төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа нь улсын хөгжлийг хангах суурь стратеги болно гэж үзэж байна.

Дээр дурдсан олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс бие даасан “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ыг батлах эрх зүйн орчинг тодорхой болгосон Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

### **Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд энэ нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батлах зохицуулалтыг нэмж тусгах зохицуулалт юм.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Төрөөс төрийн бус байгууллагатай харилцах үндсэн зарчмыг тодорхойлсон бөгөөд уг зарчмын хүрээнд Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлоготой байх, уг бодлогыг боловсруулах, батлах эрх бүхий этгээдийг энэ зүйлд тодорхойлж өгөх нь илүү нийцэлтэй гэж үзэн уг зүйлд нэмэлт оруулах төслийг боловсруулсан. Мөн Улс төрийн намын тухай, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиудаас Төрийн бус байгууллагын тухай хуульд иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах, батлахтай холбоотой зохицуулалтыг тусгах нь илүү уялдаатай гэж үзсэн болно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т бодлогын баримт бичгийг Улсын Их Хурал батлахаар заасантай нийцүүлэн боловсруулах этгээдийг Засгийн газар байх, уг бодлогын баримт бичгийг батлах эрх бүхий этгээдийг хуулийн төсөлд “Улсын Их Хурал” гэж тусгасан болно.

Түүнчлэн хуулийн төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11-д “Бусад хууль тогтоомжид заасан “төрөөс баримтлах бодлого” гэснийг энэ хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд, “үндэсний хөтөлбөр” гэснийг энэ хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно.” гэж заасантай уялдах болно.

Уг хуулийн төсөл нь ердийн журмаар хүчин төгөлдөр болох буюу уг хуулийг ердийн журмаар дагаж мөрдөх болно.

Хуулийн төсөл батлагдсанаар “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ыг батлах эрх зүйн орчин тодорхой болно.

Ингэснээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын пактад нийцүүлэх, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг тусгасан зорилтыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Хуулийн төсөл батлагдахтай холбогдуулан зардал үүсэхгүй.

----o0o----